



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2020 оны 06 сарын 30 өдөр

Дугаар 81

Мандалговь

┌ Үл хөдлөх хөрөнгө акталж, данснаас хасах ┐
зөвшөөрөл олгох тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 6.2.1, 6.4 дэх хэсгийн 6.4.6 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Сайхан-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 983,430 /есөн зуун наян гурван мянга дөрвөн зуун гуч/ төгрөгийн балансын үнэтэй, үлдэгдэл өртөггүй складны барилгыг нэгдүгээр хавсралтаар, Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 50,000/ тавин мянга/ төгрөгийн балансын үнэтэй, үлдэгдэл өртөггүй барилга байгууламжийг хоёрдугаар хавсралтаар тус тус акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

Хоёр. Сайхан-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал (С.Оюунболд), Эрүүл мэндийн төвийн дарга (Н.Бадамцэцэг) нар дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

- 2.1 Сумын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгийг акталж, данснаас хасах, акталснаас гарах материалыг борлуулж эргэлтийн хөрөнгөнд бүртгэж авахыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах.
- 2.2 Үл хөдлөх хөрөнгийг акталж, чөлөөлсөн газрыг нөхөн сэргээж байгууллагын хэрэгцээнд зориулалтаар нь ашиглах.
- 2.3 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх.
- 2.4 Энэ тогтоолын биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 06 дугаар сарын
30...ний өдрийн 81 тогтоолын хавсралт

Сайхан-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн акталж, данснаас хасах барилгын мэдээлэл

№	Барилга, байгууламж ийн нэр	зориулалт	Хэмжих нэгж		Ашиглалта д орсон огноо	Ашиглалты н нийт хугацаа /жилээр/	Балансын үнэ	Хуримтлагдса н элэгдэл	Үлдэгдэл өртөг
			Хэм жих нэгж	Биет хэмжэ э					
1	Склад	Агуулах	M2	154	1938	80	983,430	983,430 /есөн зуун наян гурван мянга дөрвөн зуун гучин төгрөг/	-
Нийт дүн									

Сайхан-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн акталж, данснаас хасах барилгын мэдээлэл

№	Барилга, байгууламж ийн нэр	зориулалт	Хэмжих нэгж		Ашиглалта д орсон огноо	Ашиглалты н нийт хугацаа /жилээр/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
			Хэм жих нэгж	Биет хэмжэ э					
1	Нүүрсний барилга	Агуулах	M2	12	2011	5	30,000	30,000	-
2	Мооргийн барилга	Шарил хадгалах	M2	5	2011	5	20,000	20,000	-
Нийт дүн									
							50,000 /гавин мянган төгрөг/	50,000 /гавин мянган төгрөг/	-